



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/462

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 22, 23 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны өвөлжилт, хаваржилтын хугацаанд зуд болсон сумдад Мал хамгаалах сангаас хямдралтай үнээр олгосон өвсний зөрүүд 8,299,200 төгрөг, Мөрөн суманд 2024 оны 07 дугаар сарын 13-аас 18-ны өдрүүдэд орсон аадар борооны улмаас үерт өртсөн айл өрхүүдийн хашааны лаг шавар гаргах, хог цэвэрлэх, элс хайргаар дүүргэх ажилд дайчлагдан ажилласан тээврийн зардлыг иргэн Г.Цэрэндоржид 3,471,000 төгрөг, Үер дайран өнгөрсөн айл өрхүүдийн хашаа, ариун цэврийн байгууламжийг ариутгахтай холбоотой зардал Мал эмнэлгийн газарт 5,350,000 төгрөг, нийт 17,120,200 төгрөгийн зардлыг баталсугай.

2.Дээрх зардлын 17,120,000 (Арван долоон сая нэг зуун хорин мянга хоёр зуун) төгрөгийн зардлыг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

